

## МОНГОЛЫН БӨӨ МӨРГӨЛИЙН СУДЛАЛ БА АКАДЕМИЧ Ч.ДАЛАЙ

О.ПҮРЭВ\*

Монголын бөөгийн шашны талаар анх удаа судалж Европод танилцуулсан хүн бол 1846 онд “Монголчуудын харын шүтлэг ба бөөгийн шашин” сэдвээр ном бичиж хэвлүүлсэн Буриадын эрдэмтэн Дорж Банзаров юм. Тэгвэл Монголын бөөг судалсан анхны европ эрдэмтэн бол 1960 онд Монголд судалгаа хийж өрнө дахинд гаргасан Унгарын эрдэмтэн Вальмаш Диосеж. Монголын бөөгийн шашны хувраг бөө мөргөлийг монголдоо судалж хятад хэлээр 1958 онд, 1959 онд монгол хэлээр Бээжин, Улаанбаатарт хэвлүүлсэн анхны хүн бол “Монголын бөө мөргөлийн товч түүх”-ийг туурвисан Чулууны Далай юм.

Ер нь “Монголын бөө мөргөлийн товч түүх” бол Ч.Далайн эрдэм судлалын ажлын эхлэл байсны дээр энэ бүтээл монголын бөөгийн шашин судлалын суурийн чулууг монголдоо анх тавьсан монгол бөө судлалын түүхэнд шинэ үеийг эхлүүлсэн бүтээл юм. Энэ бүтээлийг миний бие 1960 онд анх үзэж гэр хотлоороо амтархан уншиж зарим зүйлээр санал солилцож залуу хүү Ч.Далайд захидал бичиж байсан. Ч.Далайн энэ бүтээл бол зөвхөн монголын бөөгийн мөргөлийн түүх төдийгүй бөөгийн мөргөлийн ертөнцийг үзэх үзэл, дотоод агуулга, зан үйлийн талаар нь анх судалж бичсэн зохиол юм. Тийм ч учраас энэ бүтээлийн талаар төрийн соёрхолт зохиолч, доктор Л.Түдэв бичихдээ: “...1959 онд буюу дөчөөд жилийн тэртээ түүхч Чулууны Далайн “Монголын бөө мөргөлийн товч түүх” гэдэг бэсрэгхэн судалгааны ном Улаанбаатарт хэвлэгдсэн юм. Тэр үедээ залуухан түүхч, одоо бол нэрд гарсан академич, доктор, профессор Чулууны Далайн тэрхүү бүтээл монголчуудаас эртний шүтлэгийнхээ тухай тодорхойлон бичсэн анхны эрдэм шинжилгээний ном байсны хувьд бөө мөргөлийн судалгааны тулгуур бичиг болж бараг хагас зуун жил ганцаараа торойж байсан билээ” гэж 1999 онд бичсэн байдаг.

Ч.Далайгаас гадна монголын бөөгийн шашны талаар бүрэн ба бүрэн бусаар судалж бүтээл туурвисан Орос, зөвлөлтийн эрдэмтэн Б.Я.Владимирцов, Г.Д.Санжеев, Монгол улсын эрдэмтэн академич Б.Ринчен, угсаатны зүйч С.Бадамхатан Өвөрлөгч нутгийн Х.Буянбат, Д.Мөнгөн, Ёнсог, Л.Хурцбаатар, Ц.Үзмээ, Тайваны эрдэмтэн Хаган Чулуун, Монголын эрдэмтэн С.Дулам, Д.Буян-очир, Германы эрдэмтэн

\*О.Пүрэв-Түүхч, доктор (Ph)

В.Хайссиг, Эрика Таубе зэрэг олон эрдэмтдийг энд дурьдаж болох боловч өнөөдөр академич Ч.Далайн 70 насны ойг тохиолдуулан түүний монголын бөө мөргөлийн судалгаанд оруулсан тодорхой хувь нэмрийг анхны бүрэн хэмжээний судалгаа хийж бүтээл туурвисан Дорж Банзаровын бүтээлтэй харьцуулан үзэхийг зөвшөөрнө үү? Үүнд:

1.Дорж Банзаров Монголын бөөгийн шашны үзэл санаанд тэнгэр болон тэнгэрийн эрхэс, газар дэлхийг гал, өвөг дээдсийн сүнс-онгоныг хамааруулсан бол Ч.Далай үүний дээр өөд бологсдыг хөдөөлүүлэх ёс, хөх, цагаан өнгө, есийн тоо, зүг чигийн бэлэгдэл зэрэг монголын хэв заншлын зарим онцлогийг монгол бөөгийн шашны эрт үетэй хамааруулж үзсэн байдаг.

2.Дорж Банзаров монголын бөөгийн шашны түүхийг огт үечлээгүй бол Ч.Далай “Эртний үеийн бөө мөргөл, дундад зууны үеийн бөө мөргөл” гэж монголын түүхийн үечлэл, он дарааллын дагуу анх удаа үечилсэн байдаг.

3.Монголын бөөгийн шашны талаар бичсэн судлаачид монгол бөөгийн шашныг анхны хүй нэгдлийн үед үүссэн гэж нэгдмэл санаагаар баталсан. Гэтэл тэр хүй нэгдлийн үед эхээд сүсэг бишрэл буй болж харин бөөгийн шашин түүнээс бүр сүүлд гарч ирсэн зүйл юм гэж үзсэн. Өөрөөр хэлбэл монгол бөөгийн шашны үүслийн талаар Дорж Банзаровын тайлбарласныг улам нарийвчлан үзсэн.

4.Ч.Далай бүтээлдээ хятад сурвалж, архивын баримт маш их ашигласнаараа Дорж Банзаровын бүтээлээс хавьгүй их давуу зүйлийг монгол бөө судлалын судалгааны хүрээнд оруулж өгсөн.

5.Дорж Банзаров монгол бөөгийн шашны ертөнцийг үзэх үзлийн талаар ерөнхийд нь базаж дүгнэсэн бол Ч.Далай монголын шарын бөөгийн ертөнцийг үзэх үзлийн талаар анх удаа өргөн их материал гаргаж, санал дэвшүүлсэн хүн юм. Тэрээр Өвөр Монголын шарын бөө нарын дунд судалгаа хийж гурван ертөнцийн тухай анх гаргаж тавьсан нь түүнээс хойших судлаачид цааш нь улам нарийвчлан үзэх чиг баримжаа болсон юм.

6.Дорж Банзаров. Монгол бөөгийн шашны тэнгэр шүтлэгийн талаар их дэлгэрэнгүй авч үзсэн ч гэсэн тэнгэрийн тоо, тухайлбал 99 тэнгэрийн тухай огт дурдаагүй байхад Ч.Далай энэ бүтээлдээ М.Н.Хангалов /1958/ -ын дараа Монголдоо анх удаа тэмдэглэсэн байдаг. М.Н.Хангалов нь буриад бөөгийн хүрээнд 99 тэнгэрийн тухай гаргаж тавьсан.

7.Ч.Далай энэ бүтээлээрээ есийн тооны бэлэгдлийг бөөгийн шашны үзэл санаатай холбон авч үзэхдээ Чингисийн 9 өрлөг, 9 хот, цагаан туг, хараа ихт хар сүлд зэрэг 9-өөр бэлгэдсэн зүйлс бөөгийн шашинд байдгийг төрийн үзэлтэй холбосон нь бас анхны болсон бололтой.

8.Дорж Банзаров. 1846 онд Монголын бөөгийн шашны тухай тэр л үедээ бүрэн судалгаа хийж, судлаачдын өмнө нэгдмэл ойлголт өгч, гарын материалтай болгож өгснөөс хойш 113 жил монгол бөөгийнхүү бүрэн судлаагүй зөвхөн аль нэг талаас нь юмуу эсвэл аль нэг ястны хэмжээнд судалж ирсэн бол Ч.Далай 1958, 1959 онд монгол бөөгийн шашныг хоёрдох удаа бүрэн хэмжээгээр судалж “монголын бөө мөргөлийн товч түүх”-ийг бичсэн нь 113 жил ганцаар торойж байсан “монголчуудын харын шүтлэг ба бөөгийн шашин” Л.Түдэвийн хэлснээр дүүтэй болсон. Мэдээж урьд ургасан чихнээс хойно ургасан эвэр урт гэгчээр олон зүйлээр ахаасаа давуу байсны нэг нь Ч.Далай Хятад, өвөр монгол болон баруун монгол нутагтаа судалгаа хийсэн явдал юм. Ийнхүү судалгаа хийсэн, гаргасан бүтээл баримт дүгнэлт нь хожмын судлаачдад судалгааны ажлын чухал гарын авлага, үлгэр жишээ болдгоороо, бас гаргасан дүгнэлтүүд нь хойш хойшдоо улам бүр үнэн баттай байдгаараа монголын бөөгийн судалгаанд асар их ач холбогдолтой, тэр ач холбогдол нь хэзээ ч хуучирч өөрчлөгдөхгүй бүтээл юм.

Ч.Далайн энэ бүтээл гарснаас хойш монголын бөө судлал нэг хэсэг үедээ Өвөр Монголд нэлээд түлхүү байлаа. Энэ бүхний үндсэн дээр 1998, 1999 онд миний бие “Монгол бөөгийн шашин” гэсэн ном бичиж монголын бөө судлалд өчүүхэн хандив орууллаа. Үүнд ч Ч.Далайн бүтээл ач холбогдолтой хэвээр байна. Одоо манайд монгол бөөгийн гүн ухаан, онгод дүрслэх, эмнэг зүйн талаар мөн түүнчлэн бөө нарын увидсыг парапстхологийн талаас холбон судлах ажил эхэлж байна. Ийнхүү академич доктор Чулууны Далайн монголын бөө судлалд оруулсан мөнхийн их хувь хандив, гавъяа зүтгэлийн талаар түүний 70 насны ойн энэ хурал дээр хэдэн үг хэлэх болсондоо миний бие туйлаар баярлаж, 40 жилийн бөө судлалын зам дээр анх танилцаж нөхөрлөсөн сайн нөхөртөө эрүүл энх саруул сайхан байхыг хүсэн ерөөе.